



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 1367

Улаанбаатар хот

### “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а" дэд заалт, 29.2 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдаж байгаа “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2017 оны 11 дүгээр сарын 1-нээс 2018 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулахыг ажлын хэсэг /С.Сувд-Эрдэнэ/-т даалгасугай.

2. Болзолт уралдааныг зохион байгуулахыг дүүргийн Олимп зөвлөл /Ч.Төмөрчөдөр/-д, ерөнхий боловсролын сургуулиудыг удирдлагаар ханган бүрэн идэвхтэй оролцуулахыг Боловсролын хэлтэс /М.Цогзолмаа/-т, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Биеийн тамир, спортын хороо /С.Эрдэнэбат/-д, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Хэвлэл, мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Амартүвшин/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ